

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан нэг удаа хуралдаж, 5 асуудлыг хэлэлцэн 2 тогтоол шийдвэрийг гаргалаа. Уг хуралдаанаар “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөр, “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар аймгийн Эрүүл мэндийн газрын мэдээлэл сонсох, Улаанхус, Баяннуур сумдын Засаг даргын мэдээлэл сонсох, Алдарт эхийн I, II зэргийн одонгоор шагнуулахаар тодорхойлох тухай, Ажлын өдрийг амралтын өдөрт шилжүүлэх тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж тогтоолуудыг батлав. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар Эрүүл мэндийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлын талаар аймгийн Эрүүл мэндийн газрын дарга болон холбогдох мэргэжилтнүүд мэдээлэл тавьсан ба иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, залуучуудыг ажлын байраар хангах талаар Улаанхус сумын Засаг дарга О.Нурлан, Баяннуур сумын Засаг дарга С.Берик нар мэдээлэл хийсэн.

Казак үндэсний Наурызын баярыг тохиолдуулан “Хоггүй Өлгий” бүх нийтийн цэвэрлэгээний арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газар, Өлгий сумын Засаг даргын Тамгын газартай хамтран бүх төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулан амжилттай зохион байгуулсан.

Урьд онуудад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас насны тэтгэвэрт гарсан үе үеийн Хурлын дарга, нарийн бичгийн дарга, бусад ажилтнуудыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, нарийн бичгийн дарга нар хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулав.

Наурызын баярыг тохиолдуулан төрийн одон медалиар шагнуулахаар нийтдээ 209 хүний материалыг Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан ба үүнээс нийтдээ 96 хүн шагнагдаж, 3 дугаар сарын 21-ний өдөр аймгийн Хөгжимт Драммын театрт уг шагналыг гардуулах ажлыг зохион байгуулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн II хуралдааныг зохион байгуулж 4 байгууллагын сонсгол сонссон.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас, Тэргүүлэгчдээс гарсан шийдвэр, зохион байгуулсан ажлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудсаар тогтмол сурталчилж, мэдээ мэдээллээр хангаж ажилласан. Тухайн сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нийт 14 албан бичиг ирж, хурлаас 30 албан бичиг холбогдох газарт хүргүүлж ажиллаа. Иргэдээс 9 өргөдөл гомдол ирж хянаж хариу өглөө.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2019 оны 3 дугаар сард аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 3 удаа хуралдав. Уг хуралдаанаар аймгийн удирдлагууд тус аймагт долоо хоногт болж өнгөрсөн үйл ажиллагаануудын талаар танилцуулж, хэлтэс, агентлагийн удирдлагуудын хэрэгжүүлсэн ажил, санал, хүсэлтийг сонсож, цаг үеийн асуудлаар нийт 13 үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллав.

Энэ сард байгууллагад ирсэн Төрийн шагналаар шагнуулахаар тодорхойлсон хүмүүсийн материалыг хүлээн авч танилцан холбогдох дээд байгууллагад журмын

дагуу уламжлав. Үүнд: Төрийн шагналаар шагнуулахаар тодорхойлсон Алтанцөгц, Буянт сумдын иргэдийн материалыг хүлээн авч танилцан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмын дагуу баримт бичгийг хянан шалгаж, шаардлага хангасан иргэдийн материалыг Сангийн яам, Эрүүл мэндийн яаманд уламжлан ажилласан.

Гуравдугаар сарын 22-ний өдөр Казах түмний “Наурыз”-ын баярыг Баян-Өлгийчүүд аймгийн төв талбайд өргөн дэлгэр тэмдэглэж өнгөрүүлэв.

“Наурыз”-ын баярын нээлтийн үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн Г.Солтан, С.Эрдэнэ, Д.Мурат, Б.Наранхүү, аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан, Засаг дарга А.Гылымхан, Засаг даргын оролгч Ш.Хавыл, А.Камелият, ИТХ-ын нарийн бичгийн дарга А.Серикболат, ЗДТГ-ын дарга Х.Тилеген, Өлгий сумын ИТХ-ын дарга Х.Даулетбек, Өлгий сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч Х.Бахытхумар нар оролцож, эх орны өнцөг булан бүрт аж төрөн амьдарч байгаа нийт Казах иргэддээ болон нутгийн зон олондоо баярын мэндчилгээ дэвшүүлсэн.

Мөн Наурыз баярын босгонд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Баян-Өлгий аймгийн хоёр иргэн "гавьяат" цол хүртэж, 100 гаруй иргэн төрийн дээд одон, медалиар шагнагдав.

Энэ жилийн “Наурыз”-ын баярт домборчин хүүхэд домбор тоглож, наадамчин олныг баясгасан бол “Наурыз”-ын баярын үйл ажиллагаа үндэсний уламжлалт ёс заншлыг харуулсан баярын парадаар үргэлжилж хүүхэд өлгийдөх, бэр буулгах, зэрэг үзүүлбэрүүдийг сонирхууллаа.

Казах түмний уламжлалт "Наурыз" баярыг тохиолдуулан авьяас чадвартай, өөртөө итгэлтэй охид бүсгүйчүүдийг таниулах, үндэсний өв соёлыг сурталчлах хойч үедээ өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар, Б.Ахтаны нэрэмжит Төв номын сан хамтран М.Хурманханы нэрэмжит Хөгжимт Драмын Театрт "НАУРЫЗ БИКЕ-2019" урлаг соёлын арга хэмжээг зохион байгууллаа.

Мөн энэ сард аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын аймаг дахь салбар танхимтай хамтран “НАУРЫЗ-2019” үзэсгэлэн худалдааг аймгийн Спорт цогцолборт зохион байгуулав.

Уг үзэсгэлэн худалдаанд малчид, үйлдвэрлэгчид болон аж ахуй нэгж, байгууллагууд мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, талх нарийн боов зэрэг бараа бүтээгдэхүүнээ өргөн сонголттойгоор олны хүртээл болгов.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Санхүүгийн хяналт, аудитын албаны чиглэлээр

Тус алба нь энэ сард үйл ажиллагааны төлөвлөгөө болон Сангийн яамны удирдамжийн дагуу Засгийн газрын тусгай сан буюу аймгийн Халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангуудын 2017, 2018 онуудын үйл ажиллагаанд хяналт-шалгалт хийж, 3 дугаар сарын 10-ны дотор эцэслэн дуусгасан болно. Мөн Бугат сумын Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017, 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт-шалгалт хийж, эцэслэн дуусгасан.

Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвүүдийн 2017, 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж эхэлсэн.

Сум дундын ойн ангийн ойжуулалтын ажлын байдалд Өлгий сумын 13 дугаар багийн иргэн Х.Есенболын өргөдлийн дагуу хяналт-шалгалт хийж дуусгасан ба шалгалтын дүнг аймгийн Засаг даргад уламжилсан.

Хяналт-шалгалт явуулж тавигдсан актын төлбөрөөс урьд оны үлдэгдлээс эхний 3 сарын байдлаар өссөн дүнгээр 785.6 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулсан болно.

Энэ сард нэг төрлийн удирдамж боловсруулж, батлуулан хяналт-шалгалт хийж ажиллаж байгаа ба, мөн 14 албан бичиг хүлээн авч, хариу хүргүүлсэн.

Албанаас энэ сард 7 албан тоот бичиж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан болно. Мөн 2 төрлийн өргөдлийг хүлээн авч, урьд сард ирсэн өргөдөлтэй нийлээд 4 өргөдөлд бичгээр хариу хүргүүлсэн ба 5 өргөдөл шалгагдаж байна. Энэ сард хяналт шалгалтын үр дүнгээр 14 төрлийн төлбөрийн акт тавигдсан болно.

Албаны 2019 оны 3 дугаар сарын Зарлага, санхүүжилтийн мэдээг хуулийн хугацаанд гаргаж, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст бичгээр хүргүүлж, Шилэн дансны системд тухай бүр болон сар бүр оруулах мэдээллийг бүрэн оруулсан болно.

2019 оны 3 дугаар сарын НДШ-ийн болон татварын тайланг хугацаанд гаргаж, тухайн байгууллагуудтай тооцоо нийлсэн байгаа.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа

3.1.1. Хууль, эрх зүйн хэлтсийн мэдээлэл

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь аймгийн Засаг даргын 3 дугаар сарын 90 ширхэг А захирамжийг хянаж, Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн лавлах санд хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоол, эрх зүйн хэм хэмжээний актыг шинээр бүртгээгүй ба иргэдээс амаар болон бичгээр гаргасан хүсэлт, өргөдлийг хүлээж авч, 4 хүнд зөвлөгөө өгч үйлчлэв.

Мөн Согтууруулах ундаа худалдах нөхцөл, шаардлагыг хангаж, улсын тэмдэгтийн хураамж төлсөн 10 дэлгүүрт спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа, худалдах, тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар сунгаж, мөн 3 дэлгүүр болон түүгээр үйлчлэх 1 үйлчилгээний газарт шинээр тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар тус тус олгов.

3.1.2. Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлэл

1	Иргэдийн баримт бичгийн зөрчлийн арилгалт, хувь	99,9
2	Өөр аймаг хотоос шилжиж ирсэн	11
3	Аймаг, сум хороонд шилжиж ирсэн	93
4	Гадаад паспорт эзэмшигчдийн тоо	405
5	Шинээр гэрлэлт, /тоо/	74

3.1.3. Шүүхийн шинжилгээний албаны мэдээлэл

№	Үзүүлэлт	Тухайн	Өссөн
---	----------	--------	-------

		сар	дүн
1.	Криминалистикийн шинжилгээний тоо	3	17
2.	Хэргийн газрын үзлэгт оролцсон тоо	26	90
3.	Гутлын мөр	6	23
4.	Тээврийн хэрэгслийн мөр	4	15
5.	Эвдлэгч багажийн мөр	0	2
6.	Биологийн гаралтай ул мөр	1	1
7.	Бусад ул мөр	26	63
7.	Хонгио хошуу	0	29
8.	Гарын дардас	16	31
9.	Гарын мөр	5	6
10.	Шүүх эмнэлгийн хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо	38	141
11.	Шүүх эмнэлгийн бэлгийн холбогдолтой шинжилгээний тоо	0	1
12.	Цогцост хийсэн шинжилгээний тоо	3	9
13.	Тусгай шинжилгээ болон химийн шинжилгээний тоо	9	33

3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл (Өссөн дүнгээр)

№	Заалт	Биелэлт,хувь ,тоо
1	Цагдаагийн газрын нийт хүлээн авсан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол мэдээлэл	804
2	Бүх гэмт хэрэг	128
3	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	22,5%
4	Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	3
5	Малын хулгайн гэмт хэрэг	4
6	Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг	13
7	Нийт учирсан хохирол /сая.төг/	93,8 буюу 49,8 сая төг
8	Саатуулагдсан хүний тоо	358
9	Зөрчлийн хуулиар хэдэн хүнийг хэдэн сая төгрөгөөр торгож, арга хэмжээг авч ажилласан байдал	2804 хүнийг 116,355.0 төгрөгөөр торгов.
11	Камераар илрүүлсэн зөрчил	412
12	Нийт зөрчил	3005

3.3. Гадаадын иргэн, харьятын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн мэдээлэл

№	Заалт	Биелэлт,хувь ,тоо
1	Виз олголт	1 орны 8 гадаадын иргэнд виз олгосон
2	Түр ирэгчийн бүртгэл, хасалт	1 орны 82 гадаадын иргэнийг бүртгэж, 1 орны 71 гадаадын иргэнд хасалт хийсэн.
3	Гадаадын иргэнд визийн зөвшөөрлийн талаар	2 орны 2 иргэний визийн зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авсан.
4	Гадаадын иргэний зөрчил, түүний шийдвэрлэлт	2 орны 4 гадаадын иргэнийг 400,000.0 төгрөгөөр торгосон.
5	Иргэний харьяаллын чиглэлээр	Лавлагаа хүссэн 19 хүний өргөдлийг хүлээн авч, 2 орны 45 хүнд зөвлөгөө өгсөн
	Цагааннуур авто замын шалган нэвтрүүлэх боомтод хийгдсэн ажлын талаар	

1	Виз олголт	1 орны 4 иргэнд виз олгосон
2	Түр ирэгчийн бүртгэл, хасалт	1 орны 5 иргэнийг бүртгэж, 1 иргэнд хасалт хийсэн
3	Улсын хилээр зорчсон тухай	6 орны 2183 гадаадын иргэн улсын хилээр зорчсон. Гарах чиглэлд-1051 гадаадын иргэн Орох чиглэлд-11312 гадаадын иргэн

3.4. Онцгой байдлын газрын мэдээлэл

Нэг. Удирдлага зохион байгуулалт, дотоод ажлын талаар

Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 82 дугаар тогтоолоор улсын нөөцөөс тус аймагт 50 хувийн хямдралтай олгосон өвс, тэжээлийг хаваржилт хүндэрсэн сумдад хуваарилан тараах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2019 оны А/141 тоот захирамжаар байгуулж өвс, тэжээлийн хуваарилалтад хяналт тавин ажиллаж байна.

Хоёр. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгааны талаар

2.1.Хяналт шалгалтын талаар

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдөр баталсан “Үзвэр үйлчилгээ, соёл урлагийн байгууллагуудад хяналт-шалгалт зохион байгуулах тухай” төлөвлөгөөт, Онцгой байдлын газрын даргын 2018 оны 2 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Сагсай суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт-шалгалт явуулах тухай” төлөвлөгөөт бус гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хяналт-шалгалт явуулах удирдамжийн дагуу нийт 45 байгууллагад Галын аюулгүй байдлын тухай хууль, холбогдох дүрэм, норм стандартын хэрэгжилтийг хангуулах хяналт-шалгалт явуулж 231 зөрчил илрүүлэн 195 зөрчлийг газар дээр нь арилгуулж бусад зөрчлийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 45-ыг бичиж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

2.2.Ангиллын сургалт болон урьдчилан сэргийлэх ажлын талаар

Аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын баталсан 2019 онд зохион байгуулах гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөөний дагуу удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2 удаа 50 хүнд, мэргэжлийн ангийн сургалтыг 2 удаа 264 хүнд, ажилтны сургалтыг 2 удаа 164 хүнд, оюутан сурагчдын сургалтыг 2 удаа 197 хүнд, сайн дурын иргэдийн сургалтыг 122 хүнд тус тус зохион байгуулав.

Гал түймэр унтраах, аврах 31 дүгээр ангиас 2019 оны 1 дүгээр улиралд ангийн нэгдсэн тактикийн сургууль хийх хуваарийн дагуу 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдөр Өлгий сумын 11 дүгээр багт байрлах Ховд Их сургуулийн харьяа салбар сургуулийн барилга дотор гарсан гал түймрийг унтраах тактикийн дадлага сургууль зохион явуулав.Уг тактикийн сургуульд Онцгой байдлын газраас 32, Ховд Их сургуулийн харьяа салбар сургуулиас 152, нийт 184 алба хаагч, 4 нэгж техник оролцсон болно.

Гурав. Аюулт үзэгдэл, ослын дуудлагаар ажилласан талаар.

3.1 Объектын гал түймрийн талаар

2019 оны 3 дугаар сард Гал түймэр унтраах, аврах 31 дүгээр ангийн үйлчлэх хүрээний нутаг дэвсгэр, Өлгий сумын хэмжээнд объектын гал түймрийн 3 удаагийн

дуудлагатай байлаа. Үүнээс: Анги ажилласан-1, иргэд унтраасан-2, галын зөрчлийн дуудлага-0.

	Дуудлагын тоо	Зарцуулсан			Хүч			Хугацаа			Аварсан			Хохирол	
		Шатахуун /л/	Хөөс /л/	Ус /тн/	1 тасаг	2 тасаг	2-оос дээш тасаг	30 минут	30-60 минут	60-аас дээш	Хөрөнгө сая/	Байшин , гэр	Хүн	Том хүн	Хүүхэд
Нийт	3	23	-	4	1	-	-	1	-	-	9,6	-	-	2	-

3.2 Эрэн хайх, аврах ажиллагааны талаар: 2019 оны 03 дугаар эрэн хайх, аврах ажиллагааны дуудлага-2 байсан. Үүнд: Онцгой байдлын газраас ажилласан-2.

	Дуудлагын тоо	Шатахуун /л/	Хүн, хүч						Аварсан			Хохирол	
			ЭХАБ 1 тасаг	Бэлтгэл ээлж	Сумын мэргэжлийн	Техник	Хүн	Цаг	Хүн	Техник	Хөрөнгө/ сая/	Том хүн	Хүүхэд
Нийт	2	15	3	-	-	2	27	29	2	-	-	-	-

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.1. Эрүүл мэндийн чиглэлээр

4.1.1. Нийгмийн эрүүл мэндийн төвийн (НЭМТ) ажлын талаар

Зарим аймгуудад менингитийн өвчлөл бүртгэгдэж байгаатай холбоотой менингитийн эсрэг вакцинаар эрсдэлт бүлгийн 2-5 насны 50 хүүхдийг тархвар судлалын заалтаар дархлаажуулах үйл ажиллагаа зохион байгуулж, Жансая Өрхийн эрүүл мэндийн төвийн дархлаажуулалтын явцад хяналт үнэлгээ хийсэн.

Аймгийн Цагдаагийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн албан хаагчдад “Зөв зохистой хооллолт”, “Дархлаажуулалтын ач холбогдол”, “Эрт илрүүлгийн ач холбогдол” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 15 хүнийг хамруулсан.

Нийгмийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүд, Нэгдсэн эмнэлгийн бөөрний эмч нар, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, Жаншарапат дотрын эмнэлгийн эмч нартай хамтран Бөөр хамгаалах дэлхийн өдрийг “Эрүүл бөөр хаана, хэнд ч” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж 50 гаруй ард иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, бөөрний эмгэгийн үед хийх дасгал хөдөлгөөнийг зааж, уг эмгэгээс сэргийлэх чиглэлээр сургалт явуулж, гарын авлага тараасан.

Нийгмийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтэн, нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн эмч болон гэмтлийн эмчтэй хамтран Хилийн цэргийн 0285 дугаар

ангийн албан хаагчдад эрт илрүүлгийн ач холбогдол, амилуулах суурь тусламж, гэмтлийн үеийн суурь тусламж сэдэвт сургалт явуулж, гардан үйлдэл хийлгэсэн.

Аймгийн Эрүүл мэндийн удирдах ажилтны зөвлөгөөнд оролцогчдын биеийн жингийн индексийн /БЖИ/ үзүүлэлт буюу биеийн найрлага тодорхойлох аппаратад 42 хүнийг хамруулж, хэвийн жинтэй 17, илүүдэл жинтэй 10, таргалалтын 1-р зэрэгтэй 12, таргалалтын 2-р зэрэгтэй 2, таргалалтын 3-р зэрэгтэй 1 хүн гарсан.

Аймгийн прокурорын газрын хүсэлтийн дагуу тус байгууллагын ажилчдын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил авч, БЖИ-ийн үзүүлэлт буюу биеийн найрлага тодорхойлох аппаратад хамруулан арга зүйн зөвлөгөө өгч, нийт 14 хүн хамрагдсанаас Бие бялдрын түвшин тогтоох сорилын үнэлгээ А=4, В=7, С=3 БЖИ-ийн үнэлгээ хэвийн жинтэй 6, илүүдэл жинтэй 5, таргалалт 1-р зэрэгтэй 2, таргалалтын 2-р зэрэгтэй 1 хүн байсан.

Наурыз баярын парадын жагсаалд эрүүл мэндийн салбарын ажилчдын төлөөллүүд “Хүүхэд өлгийдөх” зан заншлын үзүүлбэрийг машин дээр чимэглэн харуулж амжилттай оролцсон.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газартай хамтран 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдөр “Сонсголоо шалгуулъя” сэдэвт өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгөөр НЭМТ-ийн мэргэжилтнүүд, аймгийн Нэгдсэн эмнэлгийн чих хамар хоолойн тасгийн хамт олон эмчийн үзлэг оношилгоо хийж, зөвлөгөө өгч, гарын авлага тарааж 100-гаад иргэнийг хамруулж, орон нутгийн радио, телевизэд ярилцлага өгч, сурталчилсан.

“Бастама” сургуулийн 7, 8-р ангийн 4 бүлгийн 103 сурагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, сонсгол хамгаалах талаар сургалт хийж, зөвлөгөө өгсөн. Үүнд дунд чихний үрэвсэлтэй 2, хатсан хулхитай 7 хүүхдийг илрүүлж эмчилсэн.

Аймгийн Цахилгаан, шугам, сүлжээний газрын 58 ажилтныг сонсголын чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар зөвлөгөө өгч, 3 ажилтанд эмчилгээ хийсэн.

Нийгмийн эрүүл мэндийн төв нь аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сүрьеэгийн диспансер, тасагтай хамтарч Дэлхий нийтээрээ “Сүрьеэтэй тэмцэх өдөр”-ийг тохиолдуулан “Сүрьеэ өвчинд анхаарал хандуулах цаг нь болсон” уриан дор өдөрлөг зохион байгуулж, 130 гаруй иргэдэд сурталчилгаа хийж, гарын авлага тарааж, сүрьеэтэй өвчтөнүүдэд туслах зорилгоор хандивын хайрцаг ажиллуулсан.

“Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин”, “Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин” гэсэн хоёр төрлийн вакциныг тус оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс шинээр нэвтрүүлж, 2, 4, 5, 9 сартай хүүхдүүдийг дархлаажуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Үүнтэй холбогдуулан 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдөр аймгийн Эрүүл мэндийн газраас “Пневмококкийн эсрэг вакцин, халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинуудыг дархлаажуулалтад нэвтрүүлэх сургалт”-ыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч, сувилагч, дархлаажуулалтын ажилтнуудыг чадваржуулах, вакцинтай холбоотой мэдээллээр хангах зорилгоор зохион байгуулсан ба сургалтад 3 сум дундын эмнэлэг, 11 сум, тосгон, 4 өрхийн эрүүл мэндийн төвүүд зэрэг анхан шатны 18 эрүүл мэндийн байгууллагуудын 72 эмч, сувилагч, дархлаажуулалтын ажилтан, аймгийн нэгдсэн эмнэлгийн 2 их эмч, Эрүүл мэндийн газрын 4 мэргэжилтэн, нийт 78 эмч мэргэжилтэн оролцлоо.

4.1.2. Эмнэлгийн тусламжийн хэлтсийн ажлын талаар

Хүүхдийн өвчний цогц менежментийн талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 3 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд 5 хоногийн сургалтыг 2 дахь удаа зохион байгуулж, сургалтад Алтай, Баяннуур, Булган, Буянт, Сагсай, Дэлүүн, Ногооннуур, Цэнгэл, Улаанхус сумууд болон Мейрим Өрхийн эрүүл мэндийн төвүүд зэрэг байгууллагуудын төлөөллүүд нийт 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон.

Эх баригч нартай байгуулах гурвалсан гэрээний загварыг боловсруулж, сум дундын эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч нарын зөвлөгөөний үеэр танилцуулан, байгууллагуудад хүргэж ажилласан.

“Амны хөндийн эрүүл мэнд” болон “Шүд эрүүл бол бие эрүүл”, хүүхдийн нүдний хугарлын гажгийг илрүүлэх зорилтын хүрээнд Баян-Өлгий аймгийн бүх сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хүүхдүүд болон сургуулийн бага насны 1-6 дугаар ангийн хүүхдүүдийг үзлэг оношилгоонд хамруулах, өвчтэй тохиолдолд эмчлэн эрүүлжүүлэх, амны хөндийн эрүүл ахуйн зөв дадал эзэмшүүлэх, хандлага өөрчлөх сургалт зохион байгуулах, шүдэнд халтай хүнсний бүтээгдэхүүн, эрүүл хооллолтын зөвлөгөө өгөх, хараа хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх чиглэлээр хамтран ажиллах гурван талт гэрээг аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Боловсрол, соёл, урлагийн газартай байгуулсан.

Сум дундын эмнэлэг, сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн сувилагч нарт “Уян зүү тавих чадварт сургах” дадлагажуулах сургалтад нийт 29 сувилагчийг хамруулсан.

Монголын дотрын сувилагчдын нийгэмлэгээс Алтай сумын эрүүл мэндийн төвд сувилагчийн тэргэнцэр, пульсоксиметр хандивласан.

Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн нярайн 1 сувилагчийг Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн Нярайн тасагт дадлагажуулах сургалтад хамруулан чадавхжуулсан.

4.1.3. Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн ажлын талаар

Аймгийн Эрүүл мэндийн газар 3 дугаар сарын 6-ны өдөр Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны аймгийн зөвлөгөөнийг “Инээмсэглэл – эерэг хандлага” сэдвээр амжилттай зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн болон сумдын Засаг дарга нар, сум, тосгон, баг, өрхийн Эрүүл мэндийн төв, Сум дундын эмнэлэг, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сансар эмнэлэг, Зооноз өвчин судлалын төвийн дарга, эрхлэгч нар, Эм холбооны тэргүүн, ЭМГ-ын дарга, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд зэрэг нийт 60 гаруй хүн оролцлоо.

Зөвлөгөөнд 2018 онд улсын хэмжээнд болон аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт хийгдсэн томоохон ажлууд, хүрсэн амжилтууд болон цаашид хамтран шийдвэрлэх тулгамдсан асуудлуудын талаар мэдээлэл хийгдэв

4.1.4. Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 3 дугаар сард хийсэн ажлын тайлан

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газартай хамтран 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдөр “Сонсголоо шалгуулъя” сэдэвт өдөрлөгийг зохион байгуулав. Тус өдөрлөгөөр НЭМТ-ийн мэргэжилтнүүд, аймгийн Нэгдсэн эмнэлгийн Чих хамар хоолойн тасгийн ажилчидтай хамтран эмчийн үзлэг оношилгоо хийж, зөвлөгөө өгч, гарын авлага тарааж 100-аад иргэнийг хамруулав.

Ерөнхий боловсролын “Бастама” сургуулийн 7, 8-р ангийн 4 бүлгийн 103 сурагчдад үзлэг хийж, зөвлөгөө өгөв. Үүнээс дунд чихний үрэвсэлтэй 2, бусад хатсан

хулхитай 7 сурагчдад зөвлөгөө өгч амбулаториор үзүүлэхийг зөвлөсөн. Мөн сурагчдад сонсголоо хамгаалах талаар мэдээлэл, сурталчилгаа хийсэн.

Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийн хүрээнд сүрьеэгийн диспансер амбулаториор үйлчлүүлэгчдэд өдөрлөг зохион байгуулж, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулсан.

4.1.5. Зоонозын өвчин судлалын төвийн (ЗӨСТ) ажлын талаар

2019 оны 2 дугаар сарын 28-наас 3 дугаар сарын 1-ний хооронд Зоонозын өвчин судлалын үндэсний төвд зохиогдсон Зоонозын төвүүдийн “Эерэг хандлага эрсдэлгүй орчин удирдах ажилтны зөвлөгөөн”-д 3 мэргэжилтэн оролцсон. Уг зөвлөгөөний үеэр тус аймгийн хамт олон “Гадаад улс салбар хоорондын хамтын ажиллагааны оны шилдэг” байгууллагаар шалгарсан.

ЗӨСТөвийн судалгаа шинжилгээний ажил сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтээс их дээгүүр оноогоор үнэлэгдэж, лабораторийн сорьц дээж илрүүлэх шалгаралтаараа улсад 3-р байр эзлэн тайланг амжилттай хамгаалсан болно.

2018 оны тайлант жилийн хугацаанд байгууллагын санхүү, тооцоонд аудитын үнэлгээ хийгдэж, мөнгө санхүүтэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болох нь аудитын дүгнэлтээр гарсан.

ТАВ.ХӨДӨӨ, АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

5.1. Хөдөө аж ахуйн талаар

Хөдөө аж ахуйн ажилтны зөвлөгөөнийг 3 дугаар сарын 11-нд зохион байгуулж уг зөвлөгөөнд сумдын Хөдөө аж ахуйн тасаг, малчин, тариаланч, үйлдвэр эрхлэгчдийн төлөөлөл нийт 100 хүн оролцов.

Зөвлөгөөн 2 хоног үргэлжилж сумдын Хөдөө аж ахуйн тасгийн дарга гартай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга гэрээ байгууллаа.

Орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжих, тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зуучлагчгүйгээр иргэдэд хүргэх зорилгоор Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран Казах түмний шинэ жилийн баяр Наурызыг угтан хүнсний бүтээгдэхүүний “Наурыз-2019” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Уг үзэсгэлэн худалдаанд 12 сум болон аймгийн төвөөс 100 орчим малчин, сүү, цагаан идээ, талх нарийн боов, зөгийн бал, казы зэрэг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэд, аж ахуйн нэгжүүд оролцож 9.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Монголын тогооч нарын холбоотой хамтран хоол үйлдвэр эрхлэгчдэд “Тогооч нарын зөвлөгөөн” сургалт, уралдааныг 2019 оны 3 дугаар сарын 27-29-ний хооронд зохион байгууллаа.

Засгийн газрын 2019 оны 23, 59 дүгээр тогтоол, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын “Хариуцлагатай хэрэглээ-Хэрэглэгчийн эрхийн жил” болгон зарласан шийдвэрийн биелэлтийг хангах, аюулгүй бараа бүтээгдэхүүнээр хангаж, бизнес эрхлэгчдийг шударгаар өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хурлын зааланд “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжье-Хариуцлагатай хэрэглээ” нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, сумдын Засаг дарга болон багийн Засаг дарга нар, Сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийн төлөөлөл 300 гаруй хүн оролцов.

2019 онд 1588 га-д тариалалт хийж, үүнээс 300 га-д төмс, 140 га-д хүнсний ногоо, 1053 га-д малын тэжээл, 95 га-д жимс, жимсгэнэ тариалж, 3641 тн төмс, 1684 тн хүнсний ногоо, 2106 тн тэжээл, 100 тн жимс, жимсгэнэ хураан авахаар төлөвлөсөн.

5.2. Мал аж ахуйн талаар

Хөдөө аж ахуйн ажилтны аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтнүүдэд болон малчдад мал аж ахуйн өнөөгийн байдал, цаашдын зорилтын талаар арга зүйн зөвлөгөө өгч сургалт явууллаа.

3 дугаар сарын 27-ны өдрийн мэдээгээр оны эхний малаас 35330 толгой мал зүй бусаар хорогдож, оны эхний 914738 толгой эх малаас 41575 толгой мал хээл хаяж, 29,1 хувь нь төллөж, 97,2 хувийн төл бойжиж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан радио хуралд оролцож, мал аж ахуйн хаваржилтын байдлын талаар танилцуулга хийж, дээрээс өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу ажил зохион байгуулсан.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Улаанбаатар хотод Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан байгаль орчин, аялал жуулчлалын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга оролцож, санамж бичигт гарын үсэг зурав.

Аймгийн хэмжээний байгалийн нөөцийн хамтын менежментийн болон ойн санг эзэмшиж буй нөхөрлөлүүдийн судалгааг гаргаж БОАЖЯ-д хүргүүллээ.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдах Өлгий сумын 3,10,12,13-р багийн нутаг дэвсгэрийг дайран өнгөрөх Олон улсын 19,2 км авто замд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж Зам тээвэр, хөгжлийн яаманд хүргүүлэв.

Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох” тухай тогтоолыг ард иргэдэд орон нутгийн радио, хэвлэл мэдээллээр сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд Монгол Улсын Шадар сайд, БОАЖСайдын хамтарсан тушаал болон БОАЖ-ын дэд сайд, Ой хээрийг түймрээс хамгаалах үндэсний зөвлөлийн даргын зөвлөмжийг сум, орон нутагт хүргүүлэн сурталчлах ажлыг зохион байгуулж, газрын даргын албан тоотыг хүргүүлэв.

Дэлхийн усны өдрийн хүрээнд Хар нуур Ховд голын сав газрын захиргаатай хамтран Өлгий сумын хэмжээнд ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан “Ус амьдралын үндэс” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Туурайтан ан амьтан аргаль хонь, янгир ямаа, халиун буга зэрэг амьтны хаваржилтын байдал хүндэрсэн бүс нутаг болох Улаанхус сумын “Баянзүрх” агнуурын бүс нутгийн “Бага асгант”, “Хараа сай”, Толбо сумын “Сайр”, “Борт уул”-ын “Мейрим дараа”, Ногооннуур сумын “Тангад”, “Модон овоо” агнуурын бүс нутгийн “Түнхэт”, “Хөндий хад”, “Ямаатын уул”, Сагсай сумын “Турган”, “Хагалгаат”ангийн бүс нутгуудад

аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн Б/10 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг өвс, давс тавьж, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлуудыг тус тус зохион байгууллаа.

Өвлийн аялал жуулчлалыг улсын хэмжээнд хөгжүүлэх зорилтын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Монголын Аялал жуулчлалын холбоо, Баян-Өлгий аймгийн Бүргэдчдийн холбоо, Улаанбаатар хот дахь Баян-Өлгий аймгийн Нутгийн зөвлөл, “Чингисийн Хүрээ” Аялал жуулчлалын цогцолбортой хамтран Улаанбаатар хотод “Нүүдэлчдийн өвөл –Бүргэдийн баяр 2019” арга хэмжээг зохион байгууллаа. Энэ жилийн бүргэдийн баярыг гадаад дотоодын нийт 20 мянга гаруй хүн үзэж, сонирхсон байна.

Өлгий сумын 1, 2, 3 дугаар ЕБС-ын сурагчдад болон хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн ахлах ангиудад Усны хэрэглээний талаар ярилцлага зохион байгууллаа.

Аймгийн Прокурорын газартай хамтран “Зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт сургалтыг сумдын байгаль хамгаалагч нарыг оролцуулан зохион байгуулж, БОХУБайцаагчийн эрх авсан байгаль хамгаалагчидтай аймгийн МХГазар, сумдын ЗДТГазар, БОАЖГазар гурвалсан гэрээ байгуулсан болно.

“Хоггүй-Өлгий” бүх нийтийн цэвэрлэгээг 3 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж Өлгий хотод орж, гарах 6 чиглэлд эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэх ажлыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар Өлгий сумын ЗДТГазартай хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Өлгий суманд үйл ажиллагаа явуулдаг 80 гаруй байгууллага аж ахуйн нэгжийн 2000 гаруй ажилчид оролцож, 20 гаруй тонн хог хаягдал цэвэрлэж, нэгдсэн хогийн цэгт буулгах ажлыг гүйцэтгүүллээ.

6.2. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр

“Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан 8 иргэнд 7567 м2, нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 42 иргэнд 30157 м2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, аймгийн Засаг даргын захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан 10 иргэнд 6341 м2 газрыг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн тус тус өмчлүүлсэн болно. Мөн 1 иргэний газар өмчлөх эрхийг өөрийн хүсэлтээр дуусгавар болгосон. 16 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаанд бүртгэн ажилласан.

Сумын газрын даамлуудаас 2017-2018 онд хийгдсэн фотомониторингын тайланг хүлээж авч нэгтгэж байна.

Аймгийн хэмжээнд хилийн цэсийн гадна болон дамнан олгосон зөрчилтэй 40 нэгж талбарын судалгааг гаргасан.

Сагсай сумын Цэнгэлдэх хүрээлэн, 1-р цэцэрлэгийн барилга, М.Икейн нэрэмжит хөшөө, Алтай сумын 100 хүүхдийн сургуулийн байршил, Цагааннуур тосгоны сургуулийн засвар, Улаанхус сумын Соёлын төвийн барилгуудын схем зургийг тус тус баталж байршлыг нь тогтоон баталгаажуулав.

Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна.

6.3. Уул уурхайн чиглэлээр

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 2 аж ахуйн нэгжийн хүсэлтийг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын хэлтэст хүргүүлэн зураг зүйн шүүлт хийлгүүлэв.

Геологи уул уурхайн салбарын зөвлөгөөнд аймгийн Засаг дарга холбогдох мэргэжилтний хамт оролцлоо.

6.4. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр

Байгууллагын ахмадын зөвлөлийг шинэчлэн байгуулав.

Аймгийн Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн үзлэгт тус газрын ажилчид хамрагдав.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Ус цаг уурын алба үүсэж хөгжсөний 95 жилийн ойн арга хэмжээнд оролцов.

“Цэнгэг ус тэгш хүртээмж-2019” сэдэвтэй Дэлхийн усны өдрийн нээлттэй хаалганы өдөрлөгт тус байгууллагын удирдлага оролцож, хэвлэл мэдээллийн хэрэгслээр Алтай Таван богд ууланд хийгдэх судалгаа шинжилгээний ажлын талаар ярилцлага өгөв.

Аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио болон Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах арга хэмжээнд байгууллагын ажилтан, албан хаагчид оролцов.

6.5. Дэд бүтцийн чиглэлээр

6.5.1. Цахилгаан хангамжийн талаар

Аймгийн хэмжээнд Баруун бүсийн эрчим хүчний системээс 8841.0 мян.кВ.цаг цахилгааныг худалдан авч, 7804.0 мян.кВ.цаг цахилгаан худалдан борлуулсан. Нийт 1037.0 мян.кВ.цаг цахилгааныг шугамд алдсан. Нийт алдагдал 11.7%-тай байгаа. Худалдан борлуулсан цахилгаанд 992.0 сая төгрөгийн нэхэмжлэл бичиж, 954.0 сая төгрөгийг цуглуулсан. Борлуулалтын орлого 96%-ийн цуглуулгатай байна.

6.5.2. Холбооны талаар

Тус газар нь 2019 оны 3 дугаар сард шуудангаар болон мэйл хаягаар компаниас 5, орон нутгийн бусад байгууллагаас 5, нийт 10 албан бичгийг хүлээж авч тухай бүр бүртгэл хөтлөн, байгууллагын удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтнуудад шилжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Мөн газрын үйл ажиллагааны асуудлуудаар албан байгууллагад 4 албан бичиг боловсруулан хүргүүлж хариу, шийдвэр гаргуулж ажиллав.

Ажиллагсдын ажлын хариуцлага, сахилгыг дээшлүүлэхэд анхаарч ажлын цагийг цаг бүртгэлийн төхөөрөмжөөр бүртгэж, хүн бүрт өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг эргэж мэдээлдэг, ажлынхаа үр дүнг сар бүр дүгнүүлдэг зэргээр ажлыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байна.

Улс, хот хоорондын сүлжээний бэлэн байдлыг хангаж, орон нутгийн иргэд, албан байгууллагууд мэдээ, мэдээллийг цаг тухай бүр, шуурхай хүлээж авах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд онцгой анхаарч аймаг, сумын шилэн кабель, кабель шугамын үзлэг, үйлчилгээг тогтмол чанартай хийж, гарсан гэмтэл саатлыг шуурхай илрүүлэн засаж, зөрчлийг арилгах арга хэмжээг байнга авч ажилласны дүнд сүлжээнд саатал гараагүй болно. Тайлант сард үндсэн SDH төхөөрөмжөөс ямар нэгэн гэмтэл саатал гараагүй болно.

Компаниас ирүүлсэн хөдөлмөр хамгаалалтай холбоотой урьдчилан сэргийлэх нэг удаагийн сэрэмжлүүлгийг тухай бүр хөдөө салбар, радио релейн станцын болон төвийн нийт ажилтнуудад танилцуулан мөрдөж ажиллаж байна.

Мөн Улсын бүртгэлийн сүлжээг шинээр хийж ажиллуулан хүлээлгэн өгсөн болно.

Өлгий сумын 1-р цэцэрлэгийн хүсэлтийн дагуу шилэн болон физик кабелийн техникийн нөхцөлийг гаргаж өгсөн. Мөн Бугат сумын Ерөнхий боловсролын сургуулийн шилэн кабелийн холболтыг хийж өгсөн.

6.5.3. Аймгийн радио телевизийн сүлжээний ажлын талаар

Сар бүр ажилчдын хурал, долоо хоног бүр чанарын хурлыг тогтмол хийж, тухай бүр ажлаа дүгнэж байна.

Наурызын баяр болон Олон улсын Эмэгтэйчүүдийн баяраар ахмадууд болон эмэгтэйчүүдийг хүлээж авч хүндэтгэл үзүүлэв.

Радио болон тоон телевизийн станцуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, гарсан гэмтэл саатлыг шуурхай засварлаж, сар бүр үзлэг үйлчилгээ хийж байна.

Сумууд дахь тоон ТВ-ийн тоног төхөөрөмжүүдэд гэмтэл саатал гараагүй хэвийн ажиллаж байна.

6.5.4. Усны талаар

Наурызын баярыг тохиолдуулан тус байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулав. Энэ арга хэмжээнд нийт 30 ахмад настан хамрагдав.

Аймгийн төв талбайд зохиогдсон “Наурыз”-ын баярын нэгдсэн жагсаалд тус компанийн нийт төлөөллүүд оролцов.

Өлгий сумын ЗДТГ, Хот тохижуулах албанаас зохион байгуулсан ариун цэврийн 10 хоногийн аяны ажилд идэвхтэй оролцож, хуваарьт газар болох байгууллагын эргэн тойронд их цэвэрлэгээ хийв.

Цэвэрлэх байгууламжийн ачаалал хэтэрч, бохир ус хайлах аюул тулгарч байгаа тул холбогдох бүхий л арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд байгууллагын ажилчид болон машин техникийг бүрэн дайчилж хэвийн ажиллагаанд оруулах арга хэмжээ авч байна.

“СУАТ” ХХКомпанийн нийт ажилчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулав.

6.5.5. Нисэх буудлын үйл ажиллагааны талаар

2019 оны 3 дугаар сарын 1-нээс 31-нийг хүртэл нийт 29 агаарын хөлөг хүлээж авснаас “Хүннү-Эйр” ХХК-ийн 19 рейсийн агаарын хөлөгөнд 480 том хүн, хагас зардал 19, амь даатгал 28, ачаа 632 ш, гар тээш 452 ш, 31 ш шуудан, “Аэро монголиа” ХХК-ийн 10 рейсийн агаарын хөлөгөнд 292 том хүн, хагас зардал 29, амь даатгал 22, ачаа 429 ш, гар тээш 285 ш, 16 ширхэг шуудан тус тус тээвэрлэсэн байна. Тээвэрлэгч компаниудын ажилчид болон нисэх буудлын ажилчдыг 552 удаа, 221 ш гар тээшийг тус тус аюулгүй байдлын үзлэгт хамруулж, ямар нэгэн зөрчилгүй нислэгийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллав.

Энэ хугацаанд тухайн аяллын рейсээр явж буй зорчигч, тээш, ачаанд 50-аас доошгүй хувьд нь биет болон сонгон үзлэг хийж, нарийн шалгаж байсны үр дүнд ямар

нэгэн зөрчил дутагдал гараагүй ба гарсан зөрчлийг цаг тухайд нь заавар, журмын дагуу арга хэмжээ авч явуулж байв.

Автомашинны шатахууны зарцуулалтын тооцоо, техник, тоног төхөөрөмжүүдийн ашиглалтад сар бүр хяналт тавьж ажиллаж байна.

Нисэх буудлын удирдах газраас ирсэн албан бичиг, судалгаануудад цаг тухайд нь хариу өгч, мэдээллээр хангаж ажиллаж байна.

6.5.6. Авто тээврийн талаар

Орон нутгийн хөрөнгөөр “Өлгий-Хашаатын” чиглэлд шинээр пост барихаар зураг төсөв нь гарсан ба одоогоор барилгын ажил эхэлж байна.

Энэ сард техникийн хяналтын үзлэгт нийт 382 тээврийн хэрэгсэл хамаарагдсанаас суудлын тээвэр 210, ачааны тээвэр 73, автобус 14, тусгай 13, механизм 22, чиргүүл 7, мотоцикл 43 тус тус бүртгэгдсэн байна.

Улс хоорондын Өлгий-Алмата хотын чиглэлд орчин үеийн АЕРО, ЮТИОНГ том оврын автобуснуудаар зорчигч тээвэрлэх, шинээр рейс нээх ажлууд явагдаж байна.

Хот хоорондын чиглэлд “Газрын Од” ХХК-ийн том оврын 24 АЕРО автобус, “Цэнгэлтранс” ХХК-ийн том оврын 15 АЕРО автобус, нийт 39 тээврийн хэрэгслээр хот хоорондын байнгын үйлчилгээнд зорчигч тээвэрлэж байна.

Энэ сард хот хооронд явсан зорчигчдын тоо 1775, рейсийн тоо 47 байна. Нийт Казахстан улс руу автобусаар явсан зорчигчдын тоо 318, рейсийн тоо 9 байна.

ДОЛОО. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

1.ӨЛГИЙ СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар

Гуравдугаар сард тус сумын Засаг даргаас нийт 25 захирамж гарч хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Ард иргэдээс 233 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх шатандаа байна.

Иргэний бүртгэлээр энэ сард 500 хүнд үйлчилгээ үзүүлснээс:

- Төрөлт	96
- Гэрлэлт	25
- Нас баралт	19
- Гэр бүл цуцлалт	1
- Үрчлэлт	8
- Дахин олголт	0
- Цахим үнэмлэх олголт	139
- Шилжих хөдөлгөөн	
- Ирсэн	59
- Явсан	0
- Овог нэр, нэр өөрчлөлт	3
- Эцэг тогтоолт	2
- Иргэний шинэчилсэн бүртгэлд	148 иргэн тус тус хамрагдсан байна.

Хоёр. Захирагчийн ажлын алба, дэд бүтэц, худалдаа, үйлчилгээний талаар

Засгийн газрын 189 дүгээр тогтоолын хүрээнд 3 дугаар сарын 1-нээс эхлэн нэг удаагийн нийлэг хальсан уутыг хүнсний үйлчилгээний газруудад хэрэглэхийг хориглосон талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ард иргэдэд мэдээлэл өгч, аж ахуйн нэгжүүдэд албан шаардлага хүргүүлсэн.

Наурыз баярыг угтаж 10 хоногийн цэвэрлэгээний аяныг зохион байгуулж, хотын гадна талын тойрог болох 6 чиглэлд хуваарийн дагуу их цэвэрлэгээний ажлыг байгууллагуудад хийлгэв.

Наурыз баярын хүрээнд төв талбайд эсгий гэр барих байршлын схем зургийг гаргаж, баталгаажуулан, сургууль цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарыг цуглуулан хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан болно.

Бүсчилсэн хөгжлийн бодлогод сумаас оруулах саналын төслийг боловсруулав.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолын дагуу 1, 8, 2, 12-р багуудын Иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулав.

Гурав. Хууль, эрх зүйн үйл ажиллагааны талаар

Аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн “Авилгаас урьдчилан сэргийлэх талаар” Өлгий сумын ЗДТГ-ын албан хаагчдад зөвлөмж сургалт явуулав.

Аймгийн Номын Сантай гэрээ байгуулж, Өлгий сумын ЗДТГ-ын алба хаагчид чөлөөт цагаа зөв, боловсон өнгөрүүлэх “Зөөврийн номын сан”-тай боллоо.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар салбар зөвлөлийн хуралд оролцов.

Аймгийн Цагдаагийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулав.

Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор Өлгий сумын Мэргэжлийн анги, Өлгий сумын ЗДТГ-ын алба хаагчдыг аюулгүй талбайд нүүлгэн шилжүүлж, нэрвэгсдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх үйл ажиллагаанд оролцов.

Ард иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэж хариу өгч, иргэдэд хуулийн зөвлөгөө өгсөн.

Дөрөв. Мал эмнэлэг, үржлийн тасгийн үйл ажиллагааны талаар

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан хөдөө аж ахуйн ажилтнуудын аймгийн зөвлөгөөнд тасгийн бүх мэргэжилтнүүд оролцож аймгийн ХХААГазрын даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээ байгуулав.

Аймгийн Онцгой байдлын газраас хөнгөлөлттэй үнээр олгосон өвс, тэжээлийг сумын иргэдэд хуваарилан олгов.

Сум хөгжүүлэх сангаас урьд жилүүдэд олгосон зээлийн нэгдсэн дүнг аймгийн ХХААГазар болон аймгийн ЗДТГазарт танилцуулан хугацаа хэтэрсэн зээлд хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар мэдээлэл өгөв.

Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт нь 21% явж байна. Мөн огт гэрээгүй маргаантай байгаа 97 зээлдэгчийн 437,182,000 сая төгрөгийн зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн эргэн төлөлтийг нь төлүүлэх ажлыг шуурхай авч хамтран ажиллаж байна.

Тав. Ариун цэвэр, хот тохижилтын талаар

Гудамж, зам, талбайн цэвэрлэгээг хийж 25 тн хогийг нэгдсэн цэгт хүргэв.

Төв талбай болон тээвэрчдийн гудамж, багуудын гэрэлтүүлгийн шугамуудын засвар үйлчилгээг хийж, шөнийн гэрэлтүүлгээр ханган ажиллаж байна.

Зургаа. Нийгмийн бодлогын талаар

Аймгийн ЭМГазрын мэргэжилтэнтэй хамтран аймгийн төвийн бүх 18 хүүхдийн цэцэрлэгээр явж үйл ажиллагаатай танилцаж, орчны ариун цэвэр болон хүүхдийн хоолны стандартад хяналт-шалгалт хийж гарсан зөрчил дутагдлуудыг арилгаж ажиллах талаар зөвлөгөө өгөв.

Хүүхэд үрчилж авахаар хүсэлт гаргасан 6 хүний материалыг хүлээн авч судлан дүгнэлт гаргаж өгөв.

Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран Өлгий сумын ахмад, настангуудад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гаргаж өгсөн.

Угаарийн хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаар багийн Засаг дарга, Багийн нийгмийн ажилтан болон Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн нартай хамтран ажиллаж байна.

Долоо. Санхүүгийн албаны талаар

Татварын орлого 2 дугаар сарын 28-ны байдлаар 157748181 төгрөг болж, төлөвлөгөө нь 195% -иар биелэгдсэн.

Байгууллагуудын сарын мэдээг хүлээн авч нэгтгэн 3 дугаар сарын 6-нд Сангийн яаманд илгээв.

2018 оны санхүүгийн нэгтгэлийн тайланг 3 дугаар сарын 11-нд төрийн аудитын газарт хүргүүлэв.

Найм. Байгаль орчин ариун цэврийн талаар

“Наурыз” баярыг угтаж Өлгий сумын ЗДТГазар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хот тохижуулах албатай хамтарч зохион байгуулсан ариун цэврийн 10 хоногийн аяны ажлын удирдамж, төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагуудад батлуулан хамтарсан хурал хийв.

Сумын Засаг даргын 1/100 тоот албан бичгийг Өлгий хотын төвд үйл ажиллагаа явуулдаг 230 аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээ, цэг салбаруудад болон 87 албан байгууллагад тарааж, бүх нийтийн цэвэрлэгээ хийлгэн байгууллагын оршин тойрны 50 м газрын хогийг ачуулав.

3 дугаар сарын 15-ны өдөр Өлгий сумын 6 чиглэлд хуваарийн дагуу 88 албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг хамруулж бүх нийтийн их цэвэрлэгээ хийлгэж эзэнгүй ил задгай хаясан хуурай хог хаягдлыг ачуулж, хотын гадна талын өнгө үзэмжийг хэвийн байдалд оруулах ажлыг зохион байгуулав.

Хотын ариун цэврийн талаар орон нутгийн радиогоор 1 удаа, телевизээр 2 удаа ард иргэдэд ухуулга сурталчилгаа хийв.

Ес: Багийн ажлын алба, багийн Засаг дарга нарын хийсэн ажлуудаас

УИХ гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханыг Өлгий сумын 12 багийн ард иргэдтэй хуваарийн дагуу уулзуулав.

Багийн Засаг дарга, багийн Нийгмийн ажилтан нар багийн нутаг дэвсгэрт байгаа эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэж, ачуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн судалгааг гаргаж аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэв.

Аймгийн Онцгой байдлын газрын сумдын гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх багийн бүрэлдэхүүнд арга зүйн дэмжлэг үзүүлэн, сургалтад баг тус бүрээс ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, цэргийн тэтгэвэртэн нарыг оролцуулав.

2. ТОЛБО СУМ

Нэг. Удирдлага зохион байгуулалт, хууль, эрх зүйн чиглэлээр

Засгийн газраас гарч буй тогтоол шийдвэрийг олон нийтэд таниулах, орон нутагт дагаж мөрдөж, хэрэгжүүлэн ажиллах зорилгоор ЗДТГ-ын албан хаагчид болон байгууллагын дарга, эрхлэгчдийн хамтарсан хуралдааныг 2 удаа зохион байгуулав.

Ерөнхий сайд У.Хүрэлсүхээс орон нутгийн удирдах албан тушаалтны Улсын зөвлөгөөний үеэр өгсөн албан даалгаврын биелэлтийг улирлаар гаргаж аймгийн ЗДТГ-т хүргүүлэв.

Төлөвлөгөөний дагуу аймгийн Онцгой байдлын газрын хяналт, бэлэн байдал хариуцсан мэргэжилтнээр ахлуулсан Гамшгаас хамгаалах ажлын хэсгийг урьж сумын гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнд эрсдэлийн үнэлгээ гаргах сургалт семинар зохион байгуулав.

Мөн 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 15:00 цагт гамшгийн аюулын дохио дуугаргаж бэлэн байдлыг шалгах арга хэмжээ авч ажиллав.

Тухайн сард баримт бичгийн стандартыг хатуу мөрдөж хэвлэмэл хуудаст тавих шаардлагыг хангаж, зориулалт эрх зүйн үндэслэлийг зөв гаргахыг холбогдох албан тушаалтанд анхааруулан ажиллаж байна.

Байгууллагаас 3 дугаар сард 80 ирсэн бичиг, 103 явуулсан бичиг, 2 аймгийн Засаг даргын захирамж, өргөдөл 37, гомдол 5, санал 10, сумын Засаг даргаас гарсан 33 захирамж, сумын Засаг даргын Тамгын газраас гарсан 15 тушаалыг, сумын Засаг даргын зөвлөлийн 7 хурлын тэмдэглэлийг тус тус бүртгэлд авч, бүртгэлийг зааврын дагуу хөтөлж ажиллав.

Хоёр. Улсын бүртгэлийн чиглэлээр

№	Бүртгэлийн нэр	Өмнөх сард хийсэн нийт бүртгэл	Тухайн сард хийсэн бүртгэл	Нийт тоо
1	Төрсний бүртгэл	15	9	24
2	Үрчилсний бүртгэл	1	0	1
3	Овог, эцэг\эх\-н нэр, нэр өөрчилсний бүртгэл	0	0	0
4	Гэрлэлтийн бүртгэл	5	1	6
5	Нас барсны бүртгэл	3	1	3
6	Иргэний үнэмлэх олголт	36	2	38
7	Шилжин явсны бүртгэл	10	17	27
8	Шилжин ирсний бүртгэл	10	6	16

9	Шинэчилсэн бүртгэл \хуурууны хээ\	33	15	38
10	Иргэний үнэмлэх дахин олголт	1	1	2

Гурав. Боловсролын талаар

Аймгийн аварга шалгаруулах теннисний тэмцээн 3 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд явагдаж тус сумаас оролцсон тамирчид эхний гурван байрыг эзэлж алт, мөнгө, хүрэл медалиар шагнагдлаа.

Мөн жүдо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнээс өсвөр үеийн тамирчид нийт 5 алт, 4 мөнгө, 6 хүрэл медалийг хүртэв.

Эмпати сургуулийн нэрэмжит математикийн олимпиадад 3-р ангийн сурагч А.Рауан 1-р байр эзлэв.

Багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх нь итгэлийн уралдааныг хоёр үе шаттайгаар зохион байгуулав.

7, 8-р ангиудын хооронд “Би багштайгаа” уралдаан тэмцээнийг, мөн эссе, гар зургийн уралдаануудыг тус тус зохион байгуулав.

9,12-р ангийг төгсөх сурагчдын судалгааг гаргав.

12-р ангийн сурагчдыг ЭЕШ-ын цахим бүртгэлд бүртгэсэн ба багш нар сурагчдаа улсын төрөлжсөн болон Бастама, Дарын сургуулийн нэрэмжит олимпиад, бага ангийн бүсийн бага олимпиадуудад бэлтгэж байна.

Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр

Тухайн сард нийтдээ 64 хүн хэвтэн эмчлүүлсэн ба амбулаторын үзлэгт 325, ор хоног 345, халдварт бус өвчний үзлэгт 78, артерийн гипертензийн үзлэгт 60 хүн, чихрийн шижингийн үзлэг шинжилгээнд 60 хүн, хөхний өмөн илрүүлэх үзлэгт 80 хүн, умайн хүзүүний өмөн илрүүлэх эсийн шинжилгээнд 9 хүнийг тус тус хамааруулав. Энэ сард дархлаажуулалтад 40 хүүхдийг хамруулав. Нийт төрөлт 7 байсан ба үүнээс аймагт 3, суманд 2 эх эсэн мэнд амаржсан.

Жирэмсний хяналтад 54 эх байгаа бөгөөд үүнээс эрсдэлтэй бүлгийн жирэмсэн эхийн тоо 11 байна.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээнд осол гэмтлээс сэргийлэх аяны ажлыг зохион байгуулж, албан байгууллага болон хувь хүмүүсийн дунд сургалт сурталчилгаа явуулав.

Үнийн хөнгөлөлттэй эмийг 45 хүнд олгосон ба 6 багийн ард иргэдийг хамааруулсан.

Цусны ерөнхий шинжилгээнд 50 хүн, шээсний шинжилгээнд 61 хүн, ДОХ болон тэмбүүгийн шинжилгээнд 15 хүн, цусанд сахар тодорхойлох шинжилгээнд 14 хүнийг тус тус хамруулав.

3. АЛТАЙ СУМ

Нэг. Удирдлага зохион байгуулалт, эрх зүйн бодлогын талаар

Сумын удирдах, гүйцэтгэх ажилтнуудын шуурхай хурлыг энэ сард 4 удаа хуралдуулж, долоо хоног бүр хийсэн ажлаа тайлагнаж, ирэх долоо хоногт хийх ажлаа

төлөвлөн ажилласан ба цаг үеийн асуудлаар нийт 25 үүрэг даалгавар өгөгдөж, 80 хувийн биелэлттэй байна.

3 дугаар сарын 19-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газар болон Эрүүл мэндийн газраас хамтран зохион байгуулсан Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны аймгийн зөвлөгөөнд сумын удирдлага, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нар оролцож аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, сумын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нар гурвалсан гэрээ байгуулав.

2019 оны 3 дугаар сарын 12-ны өдөр тус сумын Хил хамгаалах туслах хүчний орон тооны бус зөвлөл хуралдаж, 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлав. Мөн Хилийн цэргийн 0165 дугаар ангийн харьяа тус сум дахь 0147 дугаар салбарын захирагч 2018 онд хийсэн ажлын талаар товч мэдээлэл хийж, Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар батлагдсан “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам” болон 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн Хилийн тухай хуулийн талаар ойлголт өгөв. Хурлыг дүгнэж 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов.

Тус сард сумын Засаг даргын Ажлаас чөлөөлөх, Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө зарцуулах, Хүн ам, орон сууцны тооллогыг зохион байгуулах түр товчоо байгуулах, Эмэгтэйчүүдийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх комисс байгуулж, хөрөнгө зарцуулах, Асран хамгаалагч тогтоох тухай, Багийн Засаг дарга нарын цалинг шинэчлэн тогтоох, Наурызын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, Сумын Засаг даргын орлогчийн цалинг шинэчлэн тогтоох, Мал эмнэлгийн ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн сарын ажил зохион байгуулах, Наурыз-2019 үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, Ахмад настангуудад хүндэтгэл үзүүлэх, Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Газар эзэмшүүлэх, Хүүхэд харах үйлчилгээний зөвшөөрөл олгох, Иргэдийг нүүлгэн шилжүүлэх аюулгүйн талбайг сонгож батлах тухай зэрэг 17 захирамж гаргаж биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Дээд газраас болон аймгийн ЗДТГ-аас 25 албан бичиг ирж цаг тухайд нь холбогдох албан тушаалтнуудад цохолт хийж хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Мөн Засаг даргын Тамгын газраас 2 албан бичиг, Засаг даргаас 16 албан бичиг явуулсан ба бүртгэлийн дэвтэр хөтөлж боловсруулсан, нийлсэн, хянасан стандартыг мөрдөн ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам батлах тухай” 2011 оны 339, “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болгох тухай” 2017 оны 67 дугаар тогтоолуудыг тус тус хэрэгжүүлэх үүднээс аймгийн Онцгой комиссын үүргийн дагуу доорх ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Аймгийн Онцгой комиссын үүргийг хүлээж авсан даруй сумын Онцгой комиссыг хуралдуулан үүргийг нэг бүрчлэн танилцуулан, комиссын гишүүдэд үүрэг даалгавар өгч ажиллав.

2. Албан байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах бэлтгэл ажлыг хангуулан ажиллахыг үүрэг болгов.

3. Байгууллагын гамшгаас хамгаалах орон тооны бус штаб болон мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам батлах тухай” 2011 оны 339, “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болгох тухай” 2017 оны 67 дугаар тогтоолуудыг танилцуулан сургалт зохион байгуулав.

4. Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж сумын Засаг даргын 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/37 тоот захирамжаар аюулгүйн талбайг сонгож Баян-Өлгий аймгийн Алтай сумын онцгой комиссын даргын ажлын зурагт оруулан ажиллав.

5. 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 15:00 цагт Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиог дугаргаж байгууллагын Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб болон мэргэжлийн ангийг дайчлан сумын ЗДТГ, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчид, сурагчид, хүүхдүүдийг сумын Засаг даргын захирамжаар сонгогдсон аюулгүйн талбайд нүүлгэн шилжүүлж, нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэн, гарсан гал түймрийг мэргэжлийн ангийн гал түймэр унтраах бүлгийг дайчлан анхан шатны багаж хэрэгслээр унтрааж дадлага сургуулийг зохион байгуулав. Уг дадлага сургуульд нийт 180 гаруй хүн оролцов.

Хоёр. Улсын бүртгэлийн талаар

Иргэний 12 төрлийн бүртгэлийг өдөр бүр хөтлөн явуулж зохих хууль журмын дагуу гэрчилгээ олгож байна. 3 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар шинээр төрсөн 8 хүүхдэд төрсний гэрчилгээ олгож баримтжуулав. Тухайн сард шинээр гэрлэсэн 4 хосыг гэрлэлтийн бүртгэлд бүртгэв.

Шинээр иргэний үнэмлэх авах 15 иргэнийг мөн 25, 45 насны сунгалт хийлгэх нийт 12 иргэнийг шинэчилсэн бүртгэлд хамруулав. Иргэдийн гарт 18 цахим үнэмлэх олгож, ИУБ- 21 маягт бичиж мэдээллийн санд оруулав. ИГББ-н бүртгэлийн мэдээг ажлын 5 хоногт 2 удаа аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст, тухайн сарын 25-ны мэдээг сумын ЗДТГ-т тайланг өгч ажиллав.

Гурав. Хөдөө аж ахуй, газар тариалан, байгаль орчны бодлогын талаар

Наурызын баярыг тохиолдуулан "Наурыз-2019" үзэсгэлэн худалдааг сумын хэмжээнд амжилттай зохион байгуулав. Уг үзэсгэлэн худалдаанд тус сумын 25 гаруй хувиараа хөдөлмөр эрхлэгч бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид сүү, цагаан идээ, гар урлал гэх мэт төрлөөр оролцож үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдан борлуулав. Үзэсгэлэн худалдаанд оролцсон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс 10 "Шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч"-ийг сонгон шалгаруулж шагнаж урамшуулав.

Мөн Аймгийн төвд зохион байгуулагдсан "Наурыз 2019" хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаанд тус сумаас 5 хувиараа хөдөлмөр эрхлэгч сүү, цагаан идээ, гурил, гурилан бүтээгдэхүүний төрлөөр амжилттай оролцож аймгийн дүнгээр 2 дугаар байр эзлэв.

2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр сумын Засаг дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн нар 3, 5 дугаар багуудын малчин өрхүүдийн хаваржилт, мал төллөлтийн байдалтай танилцаж ажиллав. Тус газруудаар цас ихтэй өвөлжилт, хаваржилт хүндэрсэн байдалтай байна.

“Сав баглаа боодол” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж сумын Засаг даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж байна.

“Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хүрээнд сумдад үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн хүчин чадлын судалгааг дээд байгууллагаас ирсэн маягтын дагуу гаргаж аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн ба тус сумд шинээр хуурай сүүний үйлдвэр байгуулах шаардлагатай байгаа саналыг мөн уламжлав.

Сум хөгжүүлэх сангийн 1-р улирлын тайланг гаргаж графикт хугацаанд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн болно.

Тус сумын нийт багийн Засаг дарга нараас том малын зүй бус хорогдлын мэдээг хүлээн авч нэгтгэн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон Мал эмнэлгийн газарт хүргүүлэн ажиллав. 3 дугаар сарын байдлаар сумын хэмжээнд нийт 882 мал зүй бусаар хорогдсон байна.

Мөн мал төллөлт, төл бойжилтын мэдээг багийн Засаг дарга нараас авч нэгтгэн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон Мал эмнэлгийн газарт хүргүүлэв. 3 дугаар сарын байдлаар сумын хэмжээнд нийт 13730 мал төллөж, 319 төл хорогдож, 13411 төл бойжсон ба сумын хэмжээнд мал төллөлт 25,4%-тай байна.

Тус сумын нутаг дэвсгэрээс бэлтгэгдсэн мал, малын гаралтай бүтээгдэхүүн, гаднаас орж ирсэн мал амьтны Мал эмнэлгийн ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээ зохих хуул, журмын дагуу бичигдсэн эсэхэд хяналт-шалгалт хийж ажилласан ба одоогоор зөрчил илрээгүй болно

Энэ сарын 9,10 ны өдрүүдэд Хүн, малын аюулгүй байдлыг хамгаалах, мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс золбин нохой устгах ажлыг зохион байгуулав. Уг ажилд Өлгий сумын Хот тохижуулах албаны анчныг дуудаж ирүүлэн 2 өдрийн турш тус сумын Мал эмнэлэг, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд болон байгаль хамгаалагч, ЗДТГ-ын манаач нартай хамтран 28 золбин нохой устгаж ажиллав.

Наурызын баярыг угтаж албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдийн орчныг цэвэрлүүлэх тухай сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилуулан айл өрх тус бүрээр явуулан шаардлага хүргүүлж, хашааны гадна ил задгай асгасан үнс, хог хаягдлыг цэвэрлүүлэн, зөвшөөрөгдсөн цэгт хүргэж асгаж байгаа байдалд хяналт тавьж ажилласан болно.

Хууль бус агнууртай тэмцэх зорилгоор загастай голуудад тавигдах хяналтыг эрчимжүүлэн 7 хоногт 2-оос дээш удаа эргүүл хийж хяналт тавьж ажилласан ба зөрчил гараагүй болно.

Тус сумын Даваат, Шарговь, Цалгар, Халуунд хаваржиж байгаа аргалын хаваржилтын байдалд ажиглалт, судалгааг төлөвлөгөөний дагуу 1 удаа хийж фотожуулан ажилласан болно. Ажиглалт судалгаагаар аргалын хаваржилтын байдал сайн, үхэж хорогдсон асуудал тохиолдоогүй. Мөн аргалын тооллогыг хийж үзэхэд Халуунд 27, Шарговьд 15, Даваатад 17, Цалгарт 14 аргаль угалз хаваржиж байна.

Дөрөв. Боловсрол соёл, шинжлэх ухааны талаар

Төрөлжсөн олимпиадад оролцох хүүхдүүдийг шалгаруулж, бэлтгэж байна. Бага ангийн захиалсан номуудыг хуваарилалт хийж, ангиудад тарааж өгөв. Наурызын баярыг угтаж ажлын тусгай хөтөлбөр гарган анги тус бүр ангидаа хүмүүжлийн ажил зохиож, эцэг эхтэй хамтран Наурызын баярыг өргөн тэмдэглэн өнгөрүүлэв.

Өдөр бүр тогтмол бүртгэл хийж, тасаг бүрээр хүүхдийн хүмүүжлийн ажил, ариун цэврийн үйл ажиллагааг тогтмол шалгаж байна.

“Хэрэглэгчийн эрхийн өдөр”-т зориулан тусгай төлөвлөгөө гаргаж, бага ангийн багш нараар ангиудад сургалт зохион байгуулав. Сумын Олон улсын эмэгтэйчүүдийн баяр болон Монгол цэргийн баяраар сургуулийн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос хамт олны дунд мөсний баяр зохион явуулж сургуулийн бүх багш, ажилчдыг хамруулан урамшуулав.

Тав. Эрүүл мэндийн талаар

Эх хүүхдийн хяналтын чанарыг сайжруулах, ертөмтгий эмзэг бүлгийн эх хүүхдийг идэвхтэй эргэлтэд хамруулах эмчлэн эрүүлжүүлэх ажил хийгдсэн.

Жирэмсний хяналтад шинээр 9 эхийг авсан ба одоо хяналтад 53 эх байна. Ертөмтгий эмзэг бүлгийн жирэмсэн эхийн тоо 18 байна. Жирэмсэн эхчүүдэд 1 удаа сургалт зохион байгуулсан. 2 сараас – 1 нас хүртэлх 38 хүүхэд, 1 наснаас – 3 нас хүртэлх 43 хүүхэд, 3 наснаас 5 нас хүртэлх 17 хүүхдийг тус тус гэрийн идэвхтэй эргэлтээр эргэж зөвлөгөө өгсөн.

Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах хүн амын судалгааг гаргасан ба хөхний өмөнгийн үзлэгт 59 хүн хамрагдсан. Товлолын вакцинжуулалтад хамрагдвал зохих хүүхдийн нэрсийг гаргаж, тухайн сард хамрагдвал зохих нийт 52 хүүхдээс 50 хүүхэд товлолын вакцинд хамрагдсан.

Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг сум, багийн түвшинд эрчимжүүлэх, уг өвчнөөс сэргийлэх сарын аяны төлөвлөгөөний дагуу сургууль, цэцэрлэг болон бусад албан байгууллагын ажилчдад болон айл, өрх, иргэдэд чиглэсэн сургалтыг тасралтгүй явуулж байна. Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх талаар 7 сургалт хийгдэж тус сургалтад 164 хүн хамрагдаж 164 ширхэг материал тарааж өгсөн.

Засгийн газрын 224 дүгээр тушаалаар баталсан сургалтын календарьчилсан төлөвлөгөөний дагуу “Угаарын хийн хордлогоос сэргийлье”, “Осол, гэмтлээс сэргийлье”, “Малчдын эрүүл мэндийг дэмжье” сэдэвт сургалтыг 5 удаа зохион байгуулсан ба 169 хүн хамрагдсан.

Сургуулийн ахлах ангийн 104 охидод урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн бх цэцэрлэгийн 26 хүүхдэд өсөлт хөгжлийн үзлэг хийсэн.

Сүрьегийн сорьц авах, ийлдэс цуглуулан зөөвөрлөх, өвчин илэрсэн иргэдийг эмчийн хяналтад байлган эмчилгээнд хамруулах ажил хийгдэж байна.

Зургаа. Газар зохион байгуулалтын талаар

Сумын нутаг дэвсгэрт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын газрын төлбөрийг хуулийн дагуу ногдуулж сумын төсөвт төвлөрүүлж байна.

Шинээр газар эзэмшүүлэх 2 өргөдөл, газрын маргаантай 1 иргэний өргөдөл, ᠔ᠵᠡᠭᠡᠳᠡᠭᠡ тус тус ᠔ᠵᠡᠭᠡᠭᠡᠳᠡ бүртгэж, өвөлжөө, хаваржааны зориулалтаар 2 иргэний эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх сумын Засаг даргын захирамжийг үндэслэн газар эзэмших гэрээ байгуулж гэрчилгээ олгов.

Тус сард 8 иргэний нэгж талбарын хувийн хэргийг программд оруулан цахимд архивлав.

Эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ авахыг хүссэн 2 хүний материалыг бүрдүүлж, кадастрын зураг, хянан баталгааны дүгнэлт хийж, аймгийн Үл хөдлөх хөрөнгийн газарт хүргүүлсэн.

4. НОГООННУУР СУМ

Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу 2019 онд аймгийн Засаг даргаар батлуулсан Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөөний хүрээнд тус сумд Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 2019 оны 3 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Сургалтад сумын удирдлага, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, аж аухйн нэгж, байгууллагууд оролцож, болзошгүй эрсдэл, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, аврах, хамгаалах, хор уршгийг арилгах, галын аюулаас урьдчилан сэргийлэх зэрэг сэдвүүдээр сургалтыг явуулав. Уг арга хэмжээнд сумын Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн 66 хүний бие бүрэлдэхүүн хоёр хоног идэвхтэй оролцож, хувцасны болон үүргэвчийн жигдрэлтийг бүрэн хангаж ажилласан ба 3,0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулагдав. Мөн удирдах бүрэлдэхүүний зүгээс “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-ийн хүрээнд тус сум “хангалттай” гэсэн үнэлгээ авсан болно.

“Гамшгаас хамгаалах команд штабын сургууль” явагдах үед архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хориглох тухай сумын Засаг даргын 2019 оны 37 дугаар захирамж гарч биелэлтийг хангаж ажиллав.

Нийтээр амрах баярын өдрийг тохиолдуулан Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр болох 2019 оны 3 дугаар сарын 8-ны өдөр тус сумын ЗДТГ-т ажиллаж буй эмэгтэйчүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлж бэлэг гардуулав. Мөн сумын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран ажиллаж баярын хурал хийж нийт 20 гаруй эхийг шагнан урамшуулсан.

Казак үндэстний Наурыз баярыг тохиолдуулан ахмад настангуудад хүндэтгэл үзүүлж, багийн удирдлагуудтай хамтран хүндэтгэлийн зоог барив. Уг арга хэмжээнд баг бүрээс ахмад настангууд оролцож, нийт 87 хүн хамрагдсан. Мөн Наурызын баярын хөтөлбөр гаргаж үндэстний өв соёлыг сурталчлах түгээн дэлгэрүүлэхэд иргэдийг олноор хамруулах, байгууллага баг хооронд тэмцээн зохион байгуулж байр эзлүүлэх зэрэг арга хэмжээг явуулав.

Сумын хэмжээнд айл өрхүүдийн хооронд болон байгууллага бүр өөрийн эзэмшиж буй газарт их цэвэрлэгээ хийж, хог үнсийг зайлуулан Наурызын баяраар “Соёлч өрх”-ийг шалгаруулж урамшуулав.

Орчны эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний хүрээнд хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах замаар хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс сумын төвийн ойр орчмын үнс, хог, мал амьтны /нохой/ цэг зэмийг зайлуулж газар ухуулан булаж, сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллав. Үүнд 40 нохой, 79 малын цэг зэмийг зайлуулж ариун цэврийн арга хэмжээ авагдсан.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.2 дахь заалт, мөн Засгийн газрын 2019 оны 57 тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын

сайдын 2018 оны А/71 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны А/11 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хурдан морьдын Хаврын улирлын уралдааныг зохион байгуулаагүй.

Хөдөө аж ахуйн талаар:

Сумын хэмжээнд хаваржилт дунд зэргийн түвшинд байгаа ба оны эхэнд 79518 хээлтэгчээс 49227 нь төллөсөн. Төл бойжилт 53 хувьтай байна. Том малын хорогдол - 324 толгойд хүрсэн. Хээл хаялт 607 толгой байна.

5. БУЛГАН СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Тус сумын 3 дугаар сард хийхээр төлөвлөсөн ажлын биелэлтийг гаргаж, 4 дүгээр сард хийх ажлаа төлөвлөн ажиллаж байна. Долоо хоногийн 2 дахь өдөр болгон мэдээллийн цагаар хууль эрх зүйн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол хийж, албан байгууллагын дарга, эрхлэгч нар болон төсөвт байгууллагын ажилтнуудыг оролцуулж байна.

Тухайн сард Олон улсын эмэгтэйчүүдийн баярын өдөр болон Наурызын баярын өдрүүдийг зохион байгуулалттайгаар амжилттай тэмдэглэн өнгөрүүлэв.

3 дугаар сарын 21-ний өдрийн 15:00 цагт тус суманд Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх дохиог зохих журмын дагуу ажиллуулж, бүх албан байгууллагын ажилтнууд, ард иргэд, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг аюулгүй талбайд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

2. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Гуравдугаар сарын төсөвт байгууллагуудын санхүүжилт хийгдсэн ба бүх албан байгууллага цалинг зохих журмын дагуу хуваарилан олгож байна.

3. Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд

Тухайн сард мал аж ахуйн хаваржилтад онцын хүндрэл учруулаагүй, цаг агаар тогтуун байж малын хорогдол бага гарсан. Тус суманд улсын нөөцийн фондод байсан өвс, тэжээлийг 50%-ийн хямдралтайгаар тараасан нь малын хорогдол бага гарахад нөлөөлсөн.

Засгийн газрын шийдвэрээр 50%-ийн хямдралтайгаар 85 тн буюу 4250 боодол өвс, 70 тн буюу 1750 уут тэжээлийг зохих хуваарийн дагуу малчид, мал бүхий иргэдэд тарааж олгосон болно. Тухайн сарын мэдээгээр оны эхнээс 2499 толгой том мал хорогдсоноос 545 толгой эх мал байна. Энэ жилийн хувьд эх мал, ялангуяа ямаан сүрэг маш ихээр хээл хаясан мэдээтэй байгаа ба одоогийн байдлаар 9853 толгой эх мал хээл хаяснаас 9933 нь ямаа эзэлж байна. Одоогийн байдлаар нийт төллөх эх малын 22% нь төллөж 329 толгой төл хорогдон 12592 толгой төл бойжсон мэдээтэй байна. Тус суманд Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут сумдын 15 орчим өрхийн 12 мянга орчим толгой мал хаваржиж байна.

4. Үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчим хүч, дэд бүтцийн бодлогын хүрээнд

Тус сумын үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчим хүч, дэд бүтцийн ажил хэвийн явагдаж байна. Тухайн сард ард түмний өргөн хэрэглээний барааны үнэнд орсон онцын өөрчлөлтгүй хэвийн байна. Цахилгаан эрчим хүч тасалдаагүй, хэвийн ажиллаж байна.

5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны талаар

Сумын 3 сургууль, 2 хүүхдийн цэцэрлэг, соёлын төв нь зохих хөтөлбөрийнхөө дагуу хичээллэж байна. Сургуулиуд 3 дугаар сарын 2 дахь долоо хоногоос эхлэн 3-р улирлын амралтад гараад байна. 3 дугаар сард хичээлийн болон хүүхдийн спортын их наадамд 70 гаруй сурагч идэвхтэй оролцсоноос Аймгийн аваргын тэмцээнээс чөлөөт бөхөөс алт, мөнгө, хүрэл медаль, Жудо бөхөөс хүрэл медалиудыг хүртсэн байна. Хүүхдийн спортын их наадмаас чөлөөт бөхөөс алт, мөнгөн медалийг тус тус хүртсэн байна. Мөн 100 буудалт даамны тэмцээнд мөнгөн медаль авсан бол сагсан бөмбөгийн тэмцээнээс мөнгөн медаль хүртсэн амжилттай байна.

6. Эрүүл мэнд, спортын талаар

Тус сумын эрүүл мэндийн төвд тухайн сард 8 эх амаржиж, 8 хүүхэд эсэн мэнд бойжиж байна. 8 эхийн төрхийн ор хоног 57 байв. Хяналтад 84 эх байна. Нас баралт 4 гарснаас 3 эрэгтэй, 1 эмэгтэй, нас барсан байна. 0-1 насны хүүхдийн эндэгдэл 1 гарсан. Эрүүл мэндийн төвд нийт 110 хүн хэвтэн эмчлүүлсний ор хоног 663 ор хоног байна. Халдварт бус өвчлөл 74 гарсан ба шинжилгээнд 252 хүн хамрагдсан. Түргэн тусламжийн дуудлага 123 гарснаас 110 нь алсын дуудлага байв. Нийт үзлэгт бүгд 1389, урьдчилан сэргийлэх үзлэгт 396, амбулаторын үзлэгт 678 хүн тус тус хамрагдсан. Вакцинжуулалтад 146 хүүхэд хамрагдсан ба тухайн сард ханиад томуу ихтэй байсан боловч сумын Эрүүл мэндийн төвийн ажил хэвийн явагдаж байгаа болно.

6. ДЭЛҮҮН СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн ЗДТГазраас зохион явуулсан Орон нутгийн хөгжлийн санг төсөвлөх, төсөл арга хэмжээг эрэмбэлэх сургалтад сумын хөгжлийн сан хариуцсан ажилтнууд оролцов. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн өнгөрсөн жилийн ажлын үзүүлэлтээр сумын ажил сайн үнэлгээ авч нэмэгдэл урамшуулалд хамрагдах болзлыг хангасан байна.

Багийн Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч нарын хурал, уулзалтыг долоо хоног бүр тогтмол зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг тухай бүрт нь хэлэлцэн шийдвэрлэж ажиллаж байна.

Улсын нөөцөөс олгосон тэжээлийг багуудад хуваарилж өгөв. Үнэгүй ирсэн болон хөнгөлөлттэй үнээр олгох бүх төрлийн тэжээлийг тухайн үед нь тарааж өгөв.

Наурыз баярыг угтаж сумын хэмжээнд бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хамруулсан нэг өдрийн их цэвэрлэгээний ажлыг хийлгэв.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсөвт байгууллагуудад 2019 оны 3 дугаар сард хүлээн авсан санхүүжилтийг хөтөлбөр, зориулалтын дагуу хуваарилж байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургуульд 325,600.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 256,200.0 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан болно. Сумын ЗДТГ-ын хувьд 35,392.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 29,952.3 мянган төгрөгийг зарцуулсан болно. Сумын ИТХ 6,762.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 5,456.4 мянган төгрөг зарцуулсан байна. Сургуулийн өмнөх боловсрол 61,099.6 төгрөгийн санхүүжилт авч 45,545.4 мянган төгрөгийг зарцуулж өр авлагагүй ажиллаж байна. Соёлын байгууллага 19,491.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 14266,01 мянган төгрөгийг зарцуулж өр авлагагүй байна. Эрүүл мэндийн салбар 189,199.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 165,230.7 төгрөгийг зарцуулсан байгаа.

Шилэн дансны нэгдсэн системд төсөвт байгууллагуудын мэдээллийг бүрэн оруулж, сар бүр хуваарийн дагуу мэдээ мэдээллийг байршуулан Санхүүгийн албаны 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Төсөвт байгууллагуудын 2019 оны 1 дүгээр улирлын мэдээллийг төв серверт илгээж байна.

Байгууллагын нягтлан бодогч, нярав нарт төрийн сангийн үйл ажиллагааны журам, ИТХ-аас гарсан тогтоол, заавар журмуудыг танилцуулан сар болгон сургалт семинар явуулж байна. Нягтлан бодогч нарын хөдөлмөрийн гэрээнд тодорхой заалтуудыг оруулж хариуцлагыг дээшлүүлэх талаар санаачилгатай ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөөг “Шилэн дансны” систем, дундын сүлжээнд байршуулав.

Энэ сард галт зэвсгийн албан татвараас 42,000 төгрөг, улсын тэмдэгтээс 878,300 төгрөг, татварын бус орлого 100,000 төгрөг, үйл ажиллагааны орлого 3,200,000 төгрөг, хөрөнгийн орлого 15,454,782 төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 30,297,000 төгрөг, торгуулийн орлого 70,000 төгрөгийг тус тус оруулсан байна. Нийт дүн 50,420,082 орлоготой байна.

Сумын хүн ам, өрхийн бүртгэлийн программыг сар бүр хөтөлж төрсөн хүүхэд, нас барсан иргэдийн мэдээлэл, шилжиж ирсэн, шилжиж явсан иргэдийн мэдээлэл бусад мэдээллийг тухай бүр оруулж байна. Мөн сумын хөдөө аж ахуйн үнийн мэдээ, мал төллөлт, хорогдлын мэдээг статистикийн хэлтэст мэдээлж байна. Өргөн хэрэглээний барааны үнийн судалгааг сар бүрийн 18-ны дотор гаргаж байна.

Мал төллөлт хорогдлын мэдээг багийн Засаг дарга нараас авч нэгтгэн аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Сумын Онцгой комиссын бие бүрэлдэхүүн болон багийн Засаг дарга, иргэдийг оролцуулсан “Гамшгаас хамгаалах эрсдэлийн тойм судалгаа” нэртэй нэг өдрийн сургалтыг орон нутагт зохион байгуулж, гамшгийн эрсдэлийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах талаар анхны мэдэгдэхүүнтэй болов.

Сумын төвд 3 дугаар сарын 21-ний өдрийн 15 цагт зарлан мэдээллийн дохиог гурван удаа дуугаргаж гамшигт нэрвэгдсэн иргэдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх сургуулийг зохион байгуулав.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны 06/99 дугаартай Ундны усны аюулгүй байдлыг хангуулах тухай албан бичгийн дагуу “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-г боловсруулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Сумын төвийн Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Таван салаа, Болашах бага сургуулиуд хэвийн ажиллаж байна.

Сумын төвийн Ерөнхий боловсролын сургууль болон дотуур байр, эмнэлэг, хүүхдийн цэцэрлэг, хүүхэд харагч нарын үйл ажиллагаатай танилцаж хүүхдийн ирц болон дотуур байрны хүүхдийн амьдарч байгаа орчин, хоол хүнсэнд хяналт хийв.

Сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч 68 хүн, ор хоног 453, үзлэгт 1165, төрөлт 5 эх, нас баралт 5 хүн байна. Энэ сард эх, хүүхдийн эндэгдэл гараагүй болно.

Өндөр насны тэтгэвэр авагч болон бусад тэтгэвэр авагч нийт 893 хүнд 293,175,842.0 төгрөгийн тэтгэвэр, 5,239,506 төгрөгийн тэтгэмж олгосон байна. Тахир дутуугийн тэтгэвэрт 28 хүн, өндөр насны тэтгэвэрт 16 , тэжээгч алдсаны тэтгэвэрт 3 хүний материалыг хүлэн авч зохих журмын дагуу холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Сайн дурын даатгалд 13,228,200.0 төгрөгийг даатгуулсан. Эрүүл мэндийн даатгалын санд 1,260,303.0 төгрөгийг оруулан ажилласан. Албан байгууллага болон аж ахуйн нэгжийн Нийгмийн даатгалын шимтгэлийн 180,343,803.0 төгрөг оруулан ажилласан байна.

Тав. Хөдөө, аж ахуйн бодлогын хүрээнд

Тус сард аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт зохиогдсон мал аж ахуйн мэргэжилтнүүдийн 2019 оны семинар, зөвлөгөөнд ажил хэрэгчээр оролцсон ба түүний дагуу хэрэгжүүлэх ажил төрөл бүрийг цаг алдалгүй зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мал төллөлт, төл бойжилт, хаваржилтын асуудалд ач холбогдол өгч өдөр тутам хяналт тавьж ажиллав.

Шинээр үнэмлэх, тэмдэг авах шаардлагатай малчдын судалгаа захиалгыг хүлээн авч аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт захиалга хүргүүлэв.

2019 онд хийж хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан ЗДТГ-ын даргаар батлуулж, уг төлөвлөгөөний заалт бүрийг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна.

Шөвөг ярын вакциныг татаж авч вакцинжуулалтад бүх малын 50%-ийг хамруулсан.

Малын зүй бус хорогдол, төл бойжилтын мэдээг нэгтгэж аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэн ажиллаж байна. Одоогоор малын зүй бус хорогдол 7340, төл бойжилтын тоо 7600 толгой байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Загас агнах явдалд тогтмол хяналт-шалгалт хийж, байгаль орчныг хамгаалах багц хууль тогтоомжуудыг орон нутгийн иргэдэд сурталчлан ажиллаж байна.

Сумын Засаг даргын А/10 тоот захирамжаар “Наурыз” баярыг угтаж сумын орчны бохирдлыг буруулах сарын ажлыг зохион байгуулах, үнэлэлт дүгнэлт гаргах ажлын төлөвлөгөө гарган ажилласан. Үүнд: Сумын төвийн эргэн тойронд үхэж хорогдсон мал амьтны сэг зэмийг багийн Засаг дарга нартай хамтарч цуглуулан устгах ажлыг хийсэн.

Дэлгүүр болон худалдааны газруудын орчинд их цэвэрлэгээ хийлгэж үнс, хогийг ачуулах арга хэмжээ авсан.

7. ЦАГААННУУР ТОСГОН

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Удирдах ажилтны шуурхай хуралдааныг 4 удаа хуралдуулж, цаг үеийн болон төлөвлөгдсөн асуудлыг хэлэлцүүлэв.

Мөн захирагчийн зөвлөлийн хурлыг хийж тосгоны захирагчийн жилийн ажлын төлөвлөгөөг баталж, Алдарт эхийн одон авах эхүүдийн материалыг холбогдох газарт хүргүүлэв.

3 дугаар сарын 21-ний өдрийн 15:00 цагт Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дуугаргаж тосгоны байгууллагуудын ажилчдад, мэргэжлийн ангийг цуглуулж бэлэн байдлын үүргэвчийг шалган аюулгүй талбай болох тосгоны Цэнгэлдэх хүрээлэнд нүүлгэн шилжүүлэх ажиллагаа хийв. Мөн ард иргэд болон сургуулийн сурагчдад газар хөдлөлтийн үед өөрийгөө хамгаалах талаар сургалт явуулав.

Нурыз баяраар ахмад настан 86 хүнийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.

Тосгоны албан байгууллагууд, ард иргэдийн дунд үндэсний зан заншлаар “Улттык өнөр-Асыл мура” сэдэвт АСТ тэмцээнийг зохион явуулж байр эзлүүлэн шагнан урамшуулав.

Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст 1-р улирлын эрх зүйн болон нотариатын мэдээ, тосгоны Захирагчаас 1 дүгээр улиралд гарсан захирамжийг хянуулахаар хүргүүлэв.

Засгийн Газрын 384 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын А/188 дугаар захирамж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд тосгоны веб сайтад мэдээ, захирамж, төсөвт байгууллагуудын сарын мэдээ, жилийн төсөв, хөрөнгөтэй холбоотой мэдээллүүдийг тогтмол тавьж байна.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын талаар

1. Хилийн 0285-р анги	Үндсэн цалин	-	218,629,400.00 төгрөг
2. Дунд Сургууль	Үндсэн цалин	-	26,057,603.00 төгрөг
3. Хүүхдийн Цэцэрлэг	Үндсэн цалин	-	14,388,215.00 төгрөг
4. Эрүүл мэндийн төв	Үндсэн цалин	-	17,154,700.00 төгрөг
5. Соёлын төв	Үндсэн цалин	-	4,200,500.0 төгрөг
6. Зах.алба	Үндсэн цалин	-	10,076,800.00 төгрөг
Бүгд			290,507,218.00 төгрөг

Төсөвт байгууллагуудын өглөгүүд:

-Дунд сургууль	-	2,665,108.0 төгрөг
-Эрүүл мэндийн төв	-	822,750.0 төгрөг
-Соёлын төв	-	713,479.0 төгрөг
-Захирагчийн алба	-	419,151.0 төгрөгийн өглөгүүд тус тус гарсан

байна.

Гурав. Статистик мэдээний талаар

Том малын зүй бус хорогдлын мэдээ:	Хорогдсон том мал, бүгд	- 233
	Өвчнөөр хорогдсон	- 152
	Хорогдсон хээлтэгч	- 81

Дөрөв. Боловсрол, соёлын талаар

4.1. Боловсролын талаар

4.1.1. Дунд сургуулийн мэдээлэл

“Казак хэлний 7 хоног”-ийн аяныг багш нар тусгай удирдамж, төлөвлөгөөний дагуу 3 дугаар сарын 4-нөөс 12-ний өдрүүдэд амжилттай явуулав. Үүнд: “Ээжтэйгээ хамт” сэдэвт ажлыг эцэг эхчүүдийн дунд зохион байгуулж эхчүүдэд “Асыл ана” энгэрийн тэмдэг шагнан дурсгав.

“Хоггүй сургууль-Эко орчин II” сарын аяныг 2 дахь жилдээ 2-р сарын 18-наас 3-р сарын 18-нийг хүртэл амжилттай зохион явуулав. Уг аяны хүрээнд сурагчдын дунд “Хоггүй сургууль-Эко орчин” сэдэвт сургалт, “Хог хаягдал эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх вэ?” сэдэвт сургалт, “Хог хаягдлыг буцаан ашиглах” сэдэвт сургалтуудыг тус тус явуулж, мөн Эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан сургуулийн багш ажилчдын дунд “Караоке” тэмцээнийг 3-р сарын 6-ний өдөр явуулсан болно.

Сурагчид болон сургуулийн хамт олон эко орчинд амьдрах, хог хаяхгүй байх, хоггүй цэвэр орчинд сурч боловсрох зэргийг хэвшил болголоо.

3-р улирлын түвшин тогтоох шалгалтыг анги бүрээс Монгол хэл, Математик, Казак хэлний хичээлүүдээр авч анализ хийв. Мөн 9-р ангиас чанарын үнэлгээний төвөөс авсан шалгалтыг БСУГ-аас бага ангийн арга зүйч ирж зохих журмын дагуу авсан.

4.1.2. Хүүхдийн цэцэрлэгийн мэдээлэл

Энэ сард өдөрт 87 хүүхдийг хүлээн авч хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан, хөгжүүлэх үйл ажиллагааг цагийн хуваарийн дагуу чанартай явуулж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэн, хүүхэд хөгжих бүхий л боломж хэрэгцээг үндэслэн бүх талаар өв тэгш хөгжүүлэн ажиллав.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ахлах бүлгийн ээжүүд хүүхдүүдийн дунд “БАЯРЛАЛАА ЭЭЖЭЭ” тэмцээнийг зохион байгуулав.

3 дугаар улирлын үр дүнгийн урамшууллыг 6 шалгуураар дүгнэн тооцож олгов.

Тосгоны захирагчийн албанаас Наурыз баярыг тохиолдуулан байгууллагуудын дунд зохион явуулсан уралдаан тэмцээнд тус байгууллага амжилттай оролцов.

4.2. Соёлын талаар

Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан тосгоны хэмжээнд “Шилдэг ээж 2019” тэмцээнийг зохион байгуулав.

Захирагчийн албаны ажилчдын дунд “Шагайн наадгай” тэмцээн явуулав.

Наурыз баярыг тохиолдуулан Казак үндэсний өв уламжлал, соёл, үндэсний хувцас, тоглоом, наадгай, гар урлал өвийг залуу үеийнхэнд өвлүүлэх зорилгоор тосгоны албан байгууллага, ард иргэдийн дунд “Улттык өнөр- Асыл мура” АСТ тэмцээнийг явуулсан.

Тав. Эрүүл мэндийн талаар

Бүх үзлэг	-	378
-Урьдчилан сэргийлэх үзлэг	-	69
-Амбулаторийн үзлэг	-	108
-Гэрийн дуудлагын тоо	-	41
-Алсын дуудлага	-	19
-Нас баралт	-	0
-Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн	-	24
-Эмнэлгээс эмчлүүлж гарсан	-	25
-Аймагт төрсөн эх	-	2
-Өөрийн эмнэлэгт төрсөн	-	0
-Аймагт шилжүүлсэн жирэмсэн эх	-	3
-Хяналтад байгаа жирэмсэн эх	-	15

- Шинээр хяналтад авсан жирэмсэн эх - 2
- Дархлаажуулалтад - 18 иргэн тус тус хамрагдсан байна.

Зургаа. Улсын бүртгэлийн талаар

2019 оны 3 дугаар сарын 4, 5-ны өдрүүдэд УБЕГ-ын дэд дарга Д.Дэлгэрсайханаар ахлуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй сургалтын багийн Баян-өлгий аймагт зохион явуулсан Улсын бүртгэлийн багц хууль хэрэгжихтэй холбогдуулан орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад зориулсан 2 өдрийн сургалтад хамрагдав.

Мөн аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан тосгоны мэргэжлийн ангийн бэлэн байдлын үзлэг сургалтад оролцов.

Улсын бүртгэлийн 8 төрлийн бүртгэлд:

- Төрөлт - 3
- Гэрлэлт - 1
- Тараасан цахим үнэмлэх - 4
- Цахим үнэмлэх - 1
- Цахим үнэмлэх сунгалт - 1
- Үл хөдлөх гэрчилгээ олголт - 1
- Гадаад паспорт олголт - 2 тус тус бүртгэгдсэн болно.

Долоо. Нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар

Нийгмийн халамж, үйлчилгээнээс авах хүмүүсийн тэтгэвэр тэтгэмжүүдийг олгох ажлыг зохион байгуулж, Улаанбаатар хотод явж эмчилгээ хийлгэж ирсэн 5 ахмад настанд замын зардал олгов. Мөн цалинтай ээж хөтөлбөрт 2 эхийг хамруулж, 1 жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эхэд нөхцөлт мөнгөн тэтгэмж тогтоолгов.

Найм. Нийгмийн даатгалын талаар.

4 иргэнд жирэмсний амаржсаны тэтгэмж, 2 иргэнд Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгов.

Цагааннуур дахь тэтгэвэр авагчдын хувийн хэрэгт тооллого хийж аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст тооллогын хуудсыг хүргүүлэв.